

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН ДАХЬ ШУВУУ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ НЭР НЭРШИЛИЙН ТУХАЙД

Д.Отгонтуяа¹
С.Гомбобаатар²

Монголчууд эртнээс харцага, шонхор, бүргэд зэрэг хүчит шувуудыг бэлгэдэн шүтэж, овог аймаг, улс гүрний хооронд бэлэг сэлт, мэдээ хүргэх, ан гөрөө хийхдээ ашигладаг уламжлал байсныг Монголчуудын түүх, соёлын ховор нандин дурсгалууд болох Монголын Нууц Товчоо (цаашид МНТ гэх), Лу. Алтан товч (2006), мөн Марко Поло (1987)-ийн тэмдэглэл зэргээс харж болно. Тухайлбал, МНТ-ны 27-р зүйлд “Нугад ирэхүй (нугас шувууд ирэхүй) цагт харцгайгаан тийлүүлж ооров...”³; мөн 232-р зүйлд “Биднийг шувуулахуй, авлахуйд, хэвтүүл бидэн лүгээ шувуулалдан, авлалдан явтугай”⁴; Лу. Алтан Товчид “...идлэг (идлэг шонхор. хөр) шувуу мэт туулин довтлон ирэгч Хүлүг Боорчи минь”⁵; мөн “...ойн иргэдийг Жөчи оруулж, Хиргисүүдийн, түмэдийн, мянгадын ноёд, ойн иргэний ноёдыг аваад ирж Богд Чингис хаанд цагаан шонхор, цагаан агтас, хар булгадаар уулзав”⁶; цаашлаад Марко Пологийн тэмдэглэлд “Эрчүүд нь аливаад санаа зовнихгүй, аян дайн хийж, шонхор талбин араатан жигүүртэн авлана”⁷ гэжээ.

Проф. С.Дулам (2002) бүтээлдээ “Монгол домог зүй, бөө мөргөлд жигүүртэн шувуудыг дээд тивийн төрөлхтөн, тэнгэр гарвалтан хэмээн үзэх ёс бий. Төвд, Монгол Гэсэрийн туужид Гэсэр хаан дээд тивээс дунд тивд бууж ирэхдээ шувуун цээжтэй, хүн ууцтай жиг хачин, заримдаг амьтны дүрийг барьж ирдэг. Гэхдээ шувуудын дотор сайн муу хэлтэй, сайн муу ёртой шувууд гэж бий. Нөгөөтэйгүүр, шувуудын хэл нь хүмүүн бус ертөнцийн хэл мөн бөгөөд түүнийг эл ертөнцийн зарч мэдээч хэмээн төсөөлөх нь элбэг. Иймээс хон хэрээ зүүдэлбэл хэл сураг дуулна...”⁸ хэмээжээ.

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² МУИС-ийн Биологийн факультет

³ Чоймаа, Ш. (2006). Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал -1. Монголын Нууц Товчоо. Улаанбаатар. 19 дэх тал.

⁴ Чоймаа, Ш. (2006). Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал -1. Монголын Нууц Товчоо. Улаанбаатар. 181 дэх тал.

⁵ Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал -5. (2006). Эртний хаадыг үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой. Улаанбаатар., 100 дахь тал.

⁶ Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал -5. (2006). Эртний хаадыг үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой. Улаанбаатар., 156 дахь тал.

⁷ Марко Поло. (1987). Орчлонгийн элдэв сонин (Аяны тэмдэглэл). Улаанбаатар., 70 дахь тал.

⁸ Дулам, С. (2002) Монгол бэлгэдэл зүй. Зүүд совингийн бэлгэдэл зүй, цагийн бэлгэдэл зүй. Улаанбаатар., 81 дахь тал.

Бид МНТ дахь шувууны нэр, нэршил түүнтэй холбоотой хэлц, хэллэгийг нягтлан шүүж, тэдгээрийн англи орчуулга, мөн цаашид зөв орчуулах боломж зэргийг судлан үзэхийг зорьлоо. Зохиолд “Хар хур, харцгай, нугас, галуу, хун, тогоруу, харамбай нугас, шонхор, цагаан шонхор, бялзуухай, ангир, туримтай, хайргана, хараацай, хар хэрээ, бор хулд” зэрэг шувууны нэр дурьдагдах ба “Шувуу агнах”, “Шувуулах”, “Жигүүрт болж нисэх, анд шувуудыг сургах, бор шувууг анд сургах”, “Наяа бялзуур, туял (сүрэг шувуу) мэт улсыг чинь хэнд мэдүүлэх, тэд?”, “Сайн хөвүүдээр нь шувуугаа бариулж, дагуулж явагтун!” зэрэг хэлц хэллэгүүд гарч байна. Эдгээр үг, хэлц хэллэгийг хэрхэн орчуулсныг Ш.Чоймаагийн хөрвүүлэг (2006), мөн F.W.Cleaves (1982), I.Rachewiltz (2004), W.K.Sun (1957), U.Onon (2001), P.Kahn (1984), N.Dorjgotov, Z.Erendo (2006) нарын бүтээлүүдийг харьцуулан авч үзлээ.

1. МНТ –ны 25-р зүйлийн “qara quru”⁹ -ын

Хятад галиг:	中合刺中忽魯
Хятад хадмал орчуулга:	野鸡名-野雞名 (монголоор- зэрлэг гургуулын нэр)
Ш.Чоймаа	Хар хур* /*харавтар зүстэй гургуул/
F.W.Cleaves	Black pheasant
I.Rachewiltz	Grey female hawk
W.K.Sun	Woodcock
U.Onon	Black pheasant
N.Dorjgotov, Z.Erendo	Black grouse
P.Kahn	Black pheasant

Хар хур *Lyrurus tetrix* (Black grouse англиар) гэх нэгэн зүйл шувуу Хөвсгөл, Хангай, Хэнтийн нурууны ой, ойт хээр, томоохон голын шугуйгаар өвөлжиж, хавар, зундаа уулын арын битүү ойд үүрлэнэ. МНТ-д гарч буй энэ нутагт хар хур нь харьцангуй түгээмэл тархацтай, элбэг шувуу юм. Бүтээлд буй хугацааг шувууны эволюцитэй харьцуулбал урт биш юм. Өөрөөр хэлбэл, үйл явдал өрнөж буй хугацаа нь хар хурын эволюцитэй харьцуулбал харьцангуй богино. Энэ үед байсан хар хурын тархац, тохиолдоц нь одоогийнхоос бага өөрчлөгдсөн байх боломж их (Гомбобаатар ба Сумъяа, 2003) тул уг шувуу нь хар хур байх бүрэн боломжтой гэж үзэж байна. Харин зэрлэг гургуул *Phasianus colchicus* гэх шувууны тархац нь үйл явдал өрнөж буй нутгийг үл хамрах учир энэ зүйл байх нь эргэлзээтэй.

2. МНТ –ны 25, 26, 27, 28, 29, 31-р зүйлийн “bogo[q]cin qarciqai”

Хятад галиг:	中合儿赤中孩
Хятад хадмал орчуулга:	黄鷹 (монголоор- шар харцгай)
Ш.Чоймаа	борогчин харцгай* /*эм бор харцага/
F.W.Cleaves	gray falcon
I.Rachewiltz	black grouse
W.K.Sun	baby-falcon
U.Onon	female hawk
N.Dorjgotov, Z.Erendo	hen goshawk
P.Kahn	gray falcon

⁹ Igor de Rachewiltz (1972) Index to the Secret History of the Mongols. Indiana University. Bloomington.

Энэ шувууг шонхор (Cleaves, 1982), эм харцгай (Onon, 2001) гэж орчуулжээ. Үүнийг харгалзвал борогчин харцгай гэдэг нь шонхор, эсвэл харцага буюу харцгай шувуу байх боломжтой. У.Эрдэнэбат (2003)-аас үзвэл Монголчууд эртнээс харцага шувууг агнуурт ашиглаж байв. Онон, Балж голын хөндийд үлэг харцгай нь *Accipiter gentilis* (Northern Goshawk англиар) түгээмэл тохиолдох махчин шувуу юм. Гэхдээ энэ нутагт үлэг харцгайтай төсөөтэй идлэг шонхор *Falco cherrug* (Saker falcon англиар) мөн л тархжээ. Идлэг шонхор нь тал хээрийн амьдралтай бөгөөд ойн шувуу болох хар хурыг барьдаг нь эргэлзээ төрүүлнэ. Харин бусад харцгайгаас биеэр том, хүчирхэг эм үлэг харцгай нь хар хурыг агнадаг (Lewis *et al.*, 2006)-аас дүгнэвэл эм бор харцага гэдэг нь үлэг харцгайн эм нь байх боломж их байна.

3. МНТ –ны 27, 31-р зүйлийн “noqot qalawut”

Хятад галиг: 那豁揚 合兀揚

Хятад хадмал орчуулга: 鴨每 雁每

(монголоор- нугад галууд)

Ш.Чоймаа	нугад галууд
F.W.Cleaves	ducks and geese
I.Rachewiltz	ducks and wild geese
W.K.Sun	geese and ducks
U.Onon	ducks and geese
N.Dorjgotov, Z.Erendo	ducks and geese
P.Kahn	ducks and wild geese

Тэжээж сургасан харцгайгаар нугас (duck) ба галуу (goose/geese) агнадаг нь өнөөг хүртэл олон оронд уламжлагдан иржээ (Duncker, 1988; Jacobsen, 1985).

4. МНТ –ны 63, 239-р зүйлийн “caqān singqor”

Хятад галиг : 察罕 升^中豁兒

Хятад хадмал орчуулга: 白海青

(монголоор- цагаан шонхор)

Ш.Чоймаа	цагаан шонхор
F.W.Cleaves	white gerfalcons
I.Rachewiltz	white gerfalcon
W.K.Sun	white falcon
U.Onon	white gerfalcons
N.Dorjgotov, Z.Erendo	white falcon
P.Kahn	falcon

White falcon гэдэг бол цагаан шонхор *Falco rusticolus* Gyr Falcon буюу Gyrfalcon англиар)-ыг хэлжээ. Цагаан шонхор нь өнгө зүсний үндсэн гурван (цагаан, хөх саарал, бараан) хувьсалтай. Үүнээс бараан хэлбэр нь Алтайн өндөр уулсаар амьдардаг, идлэг шонхортой эрлийзжиж үүссэн эрлийз удам, эсвэл идлэг шонхорын уулын нэгэн хэлбэр байх боломжтой (Гомбобаатар, 2006). Цагаан шонхор нь биеэр том, хүчирхэг, зоригтой зэрэг шинж, Монголчууд цагаан өнгийг эрхэмлэдэг (Дулам, 2004) байсан зэргээс үзвэл их хаан цагаан шонхорыг ан ав, хүндэтгэлийн бэлэг зэрэгт ашиглаж байжээ. Харин орчин үед энэ шонхор Монгол орны Хөвсгөл, Хэнтий, Дорнод аймгийн зүүн хойд, хойд хэсгээр өвлийн цагт Монгол руу орж ирдэг зүйл болно (Gombobaatar, 2010).

Манай оронд энэ зүйлийн тоо толгой элбэг, өргөн тархацтай байсан учир тэд уг шувууг ан авд түгээмэл ашиглаж байж (Алтан товч, 2006).

5. МНТ –ны 63, 78, 199-р зүйлийн “singqor”

Хятад галиг : 升^中 鶻兒

Хятад хадмал орчуулга: 海青 (монголоор- шонхор)

Ш.Чоймаа шонхор

F.W.Cleaves gerfalcon

I.Rachewiltz gerfalcon

W.K.Sun falcon

U.Onon gerfalcon

N.Dorjgotov, Z.Erendo falcon

P.Kahn falcon

Шонхор (Gerfalcon) гэдгийг цагаан шонхор хэмээн зарим бүтээлд орчуулжээ (Cleaves, 1982; Rachewiltz, 2004; Onon, 2001). Иймээс энэ бүлэгт дурьдсан шонхор бол цагаан шонхор байх магадлал өндөр байна. Сонирхолтой нь Монгол орны уудам хээрт цагаан шонхороос гадна идлэг шонхор *Falco cherrug* нь түгээмэл тархсан бөгөөд энэ талаар аль ч бүтээлд дурьдсангүй. Уг нь биеэр цагаан шонхортой бараг адил, хүчирхэг, зоригтой энэ шувууг тэд агнууртаа ашиглах бүрэн боломжтой.

6. МНТ –ны 77-р зүйлийн “bilji’ür”

Хятад галиг : 必^勒 只儿兒

Ш.Чоймаа бялзуухай

F.W.Cleaves lark

I.Rachewiltz lark

W.K.Sun sparrow

U.Onon lark

N.Dorjgotov, Z.Erendo sparrow

P.Kahn lark

Я.Цэвэл (1966) “бялзуухай” гэдгийг жижиг шувууны нийт нэр хэмээн тодорхойлноос үзвэл энэ бүлэгт гарч буй бялзуухай буюу “bilji’ür” нь F.W.Cleaves (1982), I.Rachewiltz (2004), U.Onon (2001), P.Kahn (1984) нарын орчуулсан lark нь биднийхээр болжмор (*Melanocorypha* sp.), жиргэмэл (*Calandrella* sp.), харин Sun (1957), N.Dorjgotov, Z.Erendo (2006) нарын sparrow буюу бор шувуу нь *Passer*, *Pyrgilauda* гэх төрөлд хамаарах зүйл, мөн хээр, голын хөндийд тохиолдох шийхнүүхэй (*Anthus* sp.) байх боломжтой.

7. МНТ –ны 78-р зүйлийн “anggir”

Хятад галиг : 昂吉兒

Хятад хадмал орчуулга: 鴛鴦

(монголоор- ангир)

Ш.Чоймаа ангир

F.W.Cleaves mandarin duck

I.Rachewiltz mandarin duck

W.K.Sun a pair of teals

U.Onon yellow falcon*

*the text says *anggir* ('yellow'), which the Chinese interlinear note glosses as 'mandarin duck'. Since the mandarin duck is not particularly known for its ferocity or intolerance, 'yellow falcon' (*anggir shiba'u*) seems more appropriate.

N.Dorjgotov, Z.Erendo mandarin duck
P.Kahn mandarin duck

F.W.Cleaves (1982), I.Rachewiltz (2004), P.Kahn (1984) N.Dorjgotov, Z.Erendo (2006) нар мандир уранхажин буюу халзан ангир (Mandarin duck англиар) гэж орчуулжээ. Энэ нь шаргал өнгөгүй төдийгүй дэгдээхэйгээ барьж иддэг нь одоо хир бүртгэгдээгүй, мөн манай орны дорнод бүс нутагт 1-2 удаа бүртгэгдсэн ховор шувуу зэргээс үзвэл энэ бүлэгт гарсан ангир бол мандир уранхажин байх боломжгүй юм. Харин шаргал зүстэй, идэш тэжээл хомсдоход дэгдээхэйгээ хооллохгүй удаан хугацаагаар нуурыг орхидог, мөн нялх дэгдээхэйгээ хазаж өөрөөсөө холдуулдаг, идэш тэжээл хомс, уураг дутсан үед дэгдээхэйгээ иддэг зан төрхөөс дүгнэвэл энэ бүлэгт гарсан шувуу нь хондон ангир *Tadorna ferruginea* (Ruddy Shelduck англиар) юм.

8. МНТ –ны 85-р зүйлийн “sibawuqan-i turumtai”

Хятад галиг : 失保兀^中合泥 土^平林台

Хятад хадмал орчуулга: 雀兒 行 龍多兒

Ш.Чоймаа шувуухныг туримтай*

*начин шонхортой адилавар, бяцхан биетэй

махчин шувуу

F.W.Cleaves little bird turumtai*

* 'the name of a small bird of prey'

I.Rachewiltz sparrow-hawk

W.K.Sun a sparrow is chased by an eagle

U.Onon magpie hides in the bush from the sparrow-hawk

N.Dorjgotov, Z.Erendo sparrow

P.Kahn sparrow

Монголд оронд турамтай шонхор *Falco vespertinus* (Western red-footed falcon англиар) (Gombobaatar 2009) нь маш ховор тохиолдох зүйл бөгөөд харин түүнтэй морфологи, амьдралын хувьд нэн төсөөтэй Амарын шонхор *Falco amurensis* (Eastern red-footed falcon англиар) гэх шонхор өргөн тархжээ. Ангилал зүйн өмнөх ажлуудад энэ хоёр зүйлийг нэгэн зүйл хэмээн үзэж байлаа. Проф. Р.Чоймаа, F.W.Cleaves нар туримтай гэдэг нь нэгэн зүйл жижиг биетэй махчин шувуу гэжээ. Манай оронд буй Амарын болон турамтай шонхор нь жижиг шувуугаар үржлийн үедээ хооллодог (Шагдарсүрэн, 1964, 1983; Sabine & Stubbe, 2003)-оос дүгнэвэл энэ зүйл нь Амарын шонхор байх боломжтой юм. Нөгөө талаас, шууман шонхор *Falco subbuteo* (Eurasian hobby англиар) нь Амарын болон турамтай шонхортой ихэд төсөөтэй харагдах, үржлийн үедээ Монгол орны ой, ойт хээр, нүүдлийн үедээ уулын хээр, хээр, цөлөрхөг хээр, говь цөлийн жижиг шувуугаар голчлон хооллох ба харьцангуй өргөн тархцтай. Ийм учраас зохиолд буй махчин шувуу бол шууман шонхор байхыг ч үгүйсгэхгүй. I.Rachewiltz, W.K.Sun, Kahn, N.Dorjgotov, Z.Erendo нарын бүтээлд үүнийг бор шувуу (sparrow), U.Onon алаг шаазгай (magpie) гэж орчуулсан нь ташаа болжээ.

9. МНТ-ны 103-р зүйлийн “qarca-yin”

Хятад галиг : 合兒察因

Ш.Чоймаа хараацай

F.W.Cleaves grasshopper

I.Rachewiltz	grasshopper
W.K.Sun	-
U.Onon	swallow
N.Dorjgotov, Z.Erendo	-
P.Kahn	-

Түүхэн сурвалж бичиг, домог, үлгэр мөн тухайн зүйлийн одоогийн болон түүхэн тархац, тохиолдоц, бүтээлд буй харьцуулал зэргийг харгалзвал энэ нь алтан хараацай *Hirundo rustica* (Barn swallow англиар) байх өндөр магадлалтай.

10. МНТ –ны 111,124, 200, 210 -р зүйлийн “qara kere’e”

Хятад галиг : 中合刺鷓 鷓列額

Хятад хадмал орчуулга: 黑老鳥

(монголоор- хар хэрээ)

Ш.Чоймаа	хар хэрээ
F.W.Cleaves	black crow
I.Rachewiltz	black crow
W.K.Sun	black crow
U.Onon	black crow
N.Dorjgotov, Z.Erendo	carrion-crow/\$200 rook
P.Kahn	crow

Манай оронд хар хэрээтэй төсөөтэй хон хэрээ *Corvus corax* (Raven англиар), хар хэрээ *Corvus corone* (Carrion crow англиар), турлиах хэрээ *Corvus frugilegus* (Rook англиар) гэх шувуу бий ч хар хэрээ хэмээн бүх орчуулгад дурьджээ. Орчуулагч N.Dorjgotov, Z.Erendo (2006) нар энэ шувуу бол турлиах хэрээ байх боломжтойг өгүүлжээ. Хар хэрээ гэдэгт элдэв идэштэй хар зүстэй шувуу буюу хэрээг ерөнхийлөн ойлгосон байна. Саарал хэрээ *Corvus tristis* (Grey crow англиар) гэж нэгэн зүйл шувуу байдаг, мөн цагаан хэрээ гэж цахлайг (*Larus төрөл*) монголчууд нэрлэдэг зэргээс үзвэл хар хэрээ гэсэн нь зөв орчуулга болно. Харин “хар хэрээ” нь биологийн тухайлсан зүйлийн нэр тухайлбал, хар хэрээ, хон хэрээ алин болох нь тодорхойгүй бөгөөд биеийн хэмжээ, зан төрхийн онцлогийг нь харгалзвал энэ нь хон хэрээ байх боломжтой.

11. МНТ –ны 111 -р зүйлийн “qalawun toqura’un”

Хятад галиг : 中合鷓温 脱鷓 鷓刺兀

Хятад хадмал орчуулга: 雁 鷓 鷓

(монголоор- галууд тогорууд)

Ш.Чоймаа	галуу тогоруу
F.W.Cleaves	goose and crane
I.Rachewiltz	goose and crane
W.K.Sun	wild goose and duck
U.Onon	goose and crane
N.Dorjgotov, Z.Erendo	geese and cranes
P.Kahn	goose and crane

W.K.Sun (1957) бүтээл “Wild goose and crane” гэж орчуулжээ. Бүтээлд зэрлэг болон гэршүүлсэн галуу, тогорууны тухай өгүүлээгүй ч агуулгаас дүгнэвэл зэрлэг галуу, тогоруу юм. “Галуу тогоруу” гэсэн утга (Чоймаа, 2006) нь нэг зүйл шувууг, эсвэл галуу, тогоруу гэсэн хоёр өөр овогт хамаарагдах шувуудыг нэрлэсэн эсэх нь бас

тодорхойгүй. Бид N.Dorjgotov, Z.Erendo, (2006) нарын “geese and cranes” буюу “галуу, тогорууд” гэсэн орчуулгатай санал нэг байна.

12. МНТ –ны 111 -р зүйлийн “qun toqura’un”

Хятад галиг : 中鵞 脱鵞 合刺兀

Хятад хадмал орчуулга: 天鵝 - /鵞 鵞

(монголоор- хун тогоруу)

Ш.Чоймаа	хун тогоруу
F.W.Cleaves	swan and crane
I.Rachewiltz	swan and crane
W.K.Sun	-
U.Onon	swan and crane
N.Dorjgotov, Z.Erendo	swans and cranes
P.Kahn	swan and crane

Бидэнд буй эх сурвалжуудад хун, тогорууд (swans and cranes англиар) гэж орчуулах нь шувуу судлалын нэр томъёоны хувьд утгын алдаагүй гэж үзнэ.

13. МНТ –ны 111 -р зүйлийн “quladu mawu sibawun”

Хятад галиг : 鵞 刺都卯兀-失鵞温

Хятад хадмал орчуулга: 鳥名 歹鳥

(монголоор -шувууны нэр муу шувуу)

Ш.Чоймаа	хулд муу шувуун
F.W.Cleaves	bad the bird, the buzzard
I.Rachewiltz	buzzard’s that vile bird’s lot
W.K.Sun	-
U.Onon	bad the bird, the buzzard
N.Dorjgotov, Z.Erendo	the honey-buzzard
P.Kahn	buzzard

“Хулд” хэмээх үгийг лунь (птица) (Чермисов, 1973), сар (шувуу) (Дамдинсүрэн, 1982) гэж тайлбарлажээ. N.Dorjgotov, Z.Erendo (2006) нарынхаар “хулд” нь “honey-buzzard” буюу “гоорбис, зөгийч сар” болно. Энэ зүйл нь зөгий болон хэдгэнээр хооллох учир энэ нь хулд биш болой. К.М.Чермисов (1973), Л.С.Степанян (2003), S.Gombobaatar (2009) зэрэг бусад олон бүтээл, мөн МНТ (2006)-ны харьцуулал, үйл явдал өрнөж буй газар нутгийн байршил зэргээс шүүвэл “Хулд” гэдэг нь хулд буюу цагаан элэгт гэдэг жижиг мэрэгчдээр хооллож, томоохон голын хөндийн дагуу үүрлэдэг, (*Buteo* sp., сар buzzard англиар) шувуутай төсөөтэй ч, хун, тогорууг ангуучилдаггүй махчин шувуу болох Harrier (*Circus* sp.) байх боломжтой. Гэсэн хэдий ч, үйл явдлаас дүгнэвэл энэ бүлэг шувуунд оготно, мэрэгчдээр голчлон хооллох сар (*Buteo* төрөлд хамаарах, buzzard) шувууг ч ойлгох боломжтой юм. Иймээс дээрх орчуулгын бүтээлүүдэд buzzard хэмээн олонтаа орчуулжээ. Сар (*Buteo* sp., англиар buzzard) ба хулд (*Circus* sp., Harrier англиар) нь ангуучлах зан төрх, одоогийн болоод түүхэн тархац байршил, тоо толгой, гадаад шинж тэмдгээрээ бүтээлд буй харьцууллын шинжийг хоёулаа хангах учир чухам алин болохыг дүгнэхэд хүндрэлтэй. Харин нэрийн утгаар нь хөөж үзвэл хулд *Circus* sp., (Harrier англиар) байх боломжтой.

14. МНТ –ны 160 -р зүйлийн “qayirugana”

Хятад галиг : 中合翼 魯 中合納

Хятад хадмал орчуулга: 白 翔 雀 儿

(монголоор- халин нисэгч цагаан болжмор)

Ш.Чоймаа	хайргана*
*цагаан бор өнгөтэй, богширгоос том нэгэн зүйлийн жиргэдэг бялзуухай	
F.W.Cleaves	qayiruyana* *‘small bird with feathers’
I.Rachewiltz	skylark
W.K.Sun	lark
U.Onon	lark
N.Dorjgotov, Z.Erendo	skylark
P.Kahn	sparrow

МНТ (2006)-д гарч буй харьцууллаас дүгнэвэл том, жижиг, их, багын тухай биш, харин ойролцоо эрх мэдэл, хэмжээтэй шувуудаар өөрсдийгөө төлүүлсэн мэт. Проф. Ш.Чоймаа (2006), W.F.Cleaves (1982) нарын бүтээлээс үзвэл манай орны болжмор (Lark англиар), бор шувуу (Sparrow англиар), богширго (Skylark англиар) бүлгийн шувуудаас алаг (цагаан ба хар бараан, эсвэл бор хүрэн наснаас хамааран зүс өөр өөр) далавчтай, алаг харагдах зүйл бол Монгол болжмор *Melanocorypha mongolica* (Mongolian lark англиар) юм. Энэ нь Монгол орны тал хээрээр хамгийн өргөн тархсан, өмнө дурьдсан шувуудаас том биетэй, хээрийг төлөөлөх, үр идэштэй, уянгалаг дуутай нэгэн зүйл болно. Ялангуяа орооны үед түүний агаарт жиргэн нисэх нь тал хээрт холоос сонсогдож, алсаас тод харагдана. Гэсэн хэдий ч Монгол болжмор нь хайргана мөн болохыг батлах баримт үгүй учир “qayiruyana” хэмээн бичих нь зүйтэй юм. Харамсалтай нь Монгол орны шувуудын зүйлийн жагсаалтанд буй бор шувууны багийн жижиг шувуудын дотор энэхүү хайргана гэдэгт оноосон нэртэй зүйл алга байна.

15. МНТ –ны 160-р зүйлийн “bildü’ür”

Хятад галиг : 鶉^勑都兀^兒

Хятад хадмал орчуулга: 告天雀兒

(монголоор -тэнгэрийн шувуу)

Ш.Чоймаа	болжмор
F.W.Cleaves	bildu’ur* *‘small bird which tells Heaven, i.e., the lark’
I.Rachewiltz	lark
W.K.Sun	-
U.Onon	a distant lark*

*Jamuqa refers to two different birds in this passage, both of them similar to larks. The first is *gayiruqana*, *melanocorypha mongolica* (Eldengtei et.al. 1980) the second *bildü’ür*, *alauda alpestris* or *otocoris* Bonaparte.

N.Dorjgotov, Z.Erendo sparrow

P.Kahn lark

“Bildü’ür” гэдэг нь Монгол орны Монгол болжмортой харьцангуй ижил амьдрах орчинд тохиолдох нэгэн зүйл болжмор (англиар lark) бололтой. Англи хэлэнд “lark” гэдэгт өндөрт нисэж, уянгалаг жиргэдэг *Melanocorypha*, *Calandrella*, *Eremophila* зэрэг төрөлд хамаарагдах зүйлүүдийг ойлгодог. *Calandrella*, *Eremophila* төрөлд хамаарагдах эдгээр жижиг шувуу нь Монгол болжмороос биеэр жижиг төдийгүй, газрын гадаргын өнгөтэй адил зэгэл бор саарал зүстэй болно. Магадгүй энэ нь эдгээр бүлэг шувуугаар өөрсдийгөө төлөөлүүлэх шалтгаан болох талтай. Мөн “bildü’ür” гэдэгт шийхнүүхэй *Anthus* (Pipit англиар) зүйлүүдийг ойлгосон байх боломжтой. Ерөнхийлөн дүгнэвэл энэ нь жиргэдэг шувуудыг тэмдэглэсэн ерөнхий нэр бололтой.

16. МНТ –ны 200-р зүйлийн “boro quladu”

Хятад галиг : 李^ロ羅^中忽刺都

Хятад хадмал орчуулга: 鳥名
(монголоор- шувууны нэр)

Ш.Чоймаа бор хулд*

*элээтэй адилавтар, бие бяцхан, хулгана зэргийг барьж иддэг шувуу

F.W.Cleaves brown buzzards

I.Rachewiltz grey buzzard

W.K.Sun -

U.Onon brown buzzard

N.Dorjgotov, Z.Erendo spar hawks

P.Kahn brown vultures

Хулдын тухай дурьдсан бидний өмнөх тайлбар, агнуурын зан төрхийг харгалзан дүгнэвэл энэ шувуу бол тас (Vulture англиар), харцага (Sparrow hawk англиар) биш юм. Проф. Ш.Чоймаа (2006) нарын орчуулгаас үзвэл бор хулд нь сартай харьцуулбал элээтэй илүү төсөөтэй, мөн түүний жижиг хөхтөн ангуучилдаг зан төрх (Clarke, 1995)-ийг харгалзвал хулд гэдэг нь *Circus* sp., (англиар Harrier) байх боломжтойг өмнө дурьдсан юм.

17. МНТ –ны 200-р зүйлийн “borcin sono”

Хятад галиг : 李^兒臣莎那

Хятад хадмал орчуулга: 鴨名
(монголоор-нугасны нэр)

Ш.Чоймаа борчин соно* *борогчин нугас

F.W.Cleaves borcin sono*

*This term is glossed: “name of a [kind of] duck.”

I.Rachewiltz wild duck*

*for the enigmatic borcin sono (almost certainly a borrowing from Turkic), I have borrowed Ligeti who renders it with ‘canard sauvage’

W.K.Sun -

U.Onon drakes and ducks

N.Dorjgotov, Z.Erendo shel-duck

P.Kahn mandarin duck

Энэ нугасыг тухайлсан нэг зүйл шувуу мэтээр бичжээ. Тухайлбал, англиар Shelduck (анхидал ангир, *Tadorna tadorna*) Mandarin duck (мандир уранхажин, *Aix galericulata*) гэх мэт. Харин Проф. Ш.Чоймаа (2006), W.F.Cleaves (1982) нарын бүтээлээс харвал *Anas*, *Aythya*, *Oxyura*, *Mergus*, *Vuccephala*, *Aix* төрөлд хамаарах нэгэн зүйл нугасыг нэрлэсэн мэт. Борчин соно гэдэг нь тухайлсан нэг зүйлийг заасан зүйлийн нэр бол үүнийг нугасны зүйлүүдийн шинжтэй харьцуулах аргаар тухайн зүйлийг мэдэж болно. Энэ нь нэгэн зүйл нугасыг нэрлэсэн байх боломжтой тул цаашид “борчин соно” нэрээр бичих нь зүйтэй болов уу.

18. МНТ –ны 200-р зүйлийн “qagambai noqosu”

Хятад галиг : 中^合藍^伯 那^中豁^速

Хятад хадмал орчуулга: 黑鴨名 鴨子
(монголоор- хар нугас)

Ш.Чоймаа	харамбай нугас*	*харавтар нугас
F.W.Cleaves	qarambai* duck	*name of a [kind of] black duck
I.Rachewiltz	mandarin duck*	*one name for the mandarin duck
W.K.Sun	duck	
U.Onon	mandarin duck*	

**Qarambai nogosu* was a purple-coloured Mandarin duck (*Aix galericulata*, see Dorontib 1979, p.216, n.3 and Cihai, p.3241, Hong Kong 1979) and not, as other translators suggest, a generic term for ducks.

N.Dorjgotov, Z.Erendo	shel-drake
P.Kahn	duck

Бүтээлүүдээс үзвэл энэ нугасыг тухайлсан нэг зүйл шувуу мэтээр бичжээ. Тухайлбал, Shelduck (анхидал ангир, *Tadorna tadorna*), Mandarin duck (мандир уранхакин, *Aix galericulata*) гэх мэт. Харин Ш.Чоймаа (2006), W.F.Cleaves (1982) бүтээлийг шүүвэл *Podiceps*, *Phalacrocorax*, *Anas*, *Aythya*, *Oxyura*, *Vucephala*, *Melanitta*, төрөлд хамаарах бараан зүстэй нэгэн зүйл нугасыг нэрлэсэн байх талтай. Мандир уранхажин нь бараан зүстгүй бөгөөд иймээс энэ үгийг “харамбай” хэмээн бичих нь зүйтэй мэт санагдана.

19. МНТ –ны 195 –р зүйлийн “*byeseksen sibawun*”

Хятад галиг : 失鹄温

Хятад хадмал орчуулга: 鷹

(монголоор- харцгай)

Ш.Чоймаа	өлссөн шувуу
F.W.Cleaves	driveling like falcons
I.Rachewiltz	like a greedy, slaving falcon
W.K.Sun	hungry hawk
U.Onon	slaving like a starved falcon
N.Dorjgotov, Z.Erendo	prying eyes of a starved falcon
P.Kahn	like a falcon hungry for food

МНТ-д гарч буй шувуутай холбоотой хэлцүүд дэх шувуу хэмээх үгийг харцгай гэсэн утгатай хятад ханзаар хадаж орчуулсан нь сонирхолтой байна.

20. МНТ –ны 199-р зүйлийн “*ji’urtu bolju niscu*”

Ш.Чоймаа	жигүүрт болж нисч
F.W.Cleaves	if those, becoming winged, flying, ascend unto Heaven
I.Rachewiltz	if they grow wings and fly up into the sky
W.K.Sun	if they fly on wings to the sky
U.Onon	if they grow wings and fly up into the sky
N.Dorjgotov, Z.Erendo	if they grow wings and soar into the sky
P.Kahn	if they sprout wings and fly up toward Heaven

21. МНТ –ны 54,189, 232, 233-р зүйлийн “*sibawulan, sibawulaqu, sibawulaqui*”

Ш.Чоймаа	шувуулан явахуйд*	*шонхор, харцгайгаар ан хийх явахад
F.W.Cleaves	falconing	
I.Rachewiltz	hunting with falcons/ falconry and hunting/	
	go falconing and hunting	
W.K.Sun	hawking/hunting/falconry	
U.Onon	flying hawks/ falconry and hunting/	

- go falconry and hunting
 N.Dorjgotov, Z.Erendo hawking/falconry and hunting/ go falconing and hunting
 P.Kahn hunting with falcons/ hunt
- Проф.Ш. Чоймаа (2006)-гийн хөрвүүлэгт шувуулан явахууд (шонхор, харцгайгаар ан хийн явахад) гэдэгт шонхор, харцгайн тусламжтай шувуу, хөхтнийг агнахыг хэлжээ. Энэ баримт болон У.Эрдэнэбат (2003)-аас дүгнэвэл Монголчууд зөвхөн шонхороор бус мөн харцага/ харцгай (*Accipiter* төрлийн шувууд)-г шувуулахууд ашиглаж байсан нь тодорхой.
22. МНТ –ны 220-р зүйлийн “naya’a-bilji’ür”
 Ш.Чоймаа Наяа бялжуур*
 *бялзуухай жиргэх мэт хэмээсэн хоч
 F.W.Cleaves Naya’a ‘The Lark’
 I.Rachewiltz Naya’a Bilji’ür
 W.K.Sun Naya
 U.Onon Naya’a
 N.Dorjgotov, Z.Erendo Naya
 P.Kahn Nayaga
23. МНТ –ны 245, 254 -р зүйлийн “Tuyal metü ulus cinu”
 Ш.Чоймаа Туял* мэт улсыг чинь
 Хэнд мэдүүлэх, гэд? *сүрэг шувуу чуулсан мэт
 F.W.Cleaves Tumbleth down,
 Thy peoples like [unto] a flock of birds
 I.Rachewiltz By whom will they let govern your people
 Who are like a flock of birds?
 W.K.Sun flocks of birds
 U.Onon Who will they then let govern your people, who are as
 [a flock of] red-polls?
 N.Dorjgotov, Z.Erendo Whom will they then let govern Your people like flock
 of birds?
 P.Kahn When your body crumbles like an old pillar who will
 lead your people, these great flocks of birds?

“Энэ үг (tuyal)-ийн нангиад эхийг үзвэл (§245) 群鸟 qúnniāo (“сүрэг шувуу”), (§254) 雀群 quèqún (“бялзуухайн сүрэг”) гэсэн утгатай ханз байх юм. Эртний Түрэг хэлний 𐰽𐰺𐰍 tunyluγ (tunyalīγ) үгийг “бат бэх, тулгууртайн учир хүч чадалтай, тогтвортой” гэсэн утгатай хэмээн үзэж байна.”¹⁰

“Туял” гэдгийг зүйлийн нэр нь тодорхойгүй сүрэг шувуу гэсэн ерөнхий утгаар хэрэглэвэл зохино.

24. МНТ –ны 249-р зүйлийн “o’orqu sibawun surqaju”
 Ш.Чоймаа Оорох шувуун* сургаж *ан авд тавих шувуунд
 F.W.Cleaves teaching birds* * falcon
 I.Rachewiltz training falcons to fly loose at game,
 W.K.Sun will present falcons and hawks
 U.Onon will train falcons

¹⁰ Баттулга Ц. (2005) Монголын руни бичгийн бага дурсгалууд. Улаанбаатар. 138 дахь тал.

N.Dorjgotov, Z.Erendo we shall train falcons.....
 P.Kahn we will give him the best of the birds we've trained for
 the hunt

Махчин шувуугаар ангуучлахдаа тэдгээрийг хөхтөн, шувуу барихад сургадаг зан үйл одоо хир дэлхийд бий. Монголчууд энэ талаар туршлага их хуримтлуулсан ард түмэн бөгөөд харамсалтай энэ талаар үлдсэн баримт, материал хомс байна. Ер нь энэ чиглэлийн судалгааг үргэлжлүүлэх нь махчин шувуу судлалд чухал ач холбогдолтой.

25. МНТ –ны 260 -р зүйлийн “bogo sibawun bauliya-tur sayi oroqu metü”

Ш.Чоймаа Бор шувуу буулианд сая орох мэт
 F.W.Cleaves as gray falcons but enter into training
 I.Rachewiltz like grey falcons that have just begun training,
 W.K.Sun young eagles are learning to fly
 U.Onon like young falcons about to enter training
 N.Dorjgotov, Z.Erendo like sparrow-hawks being trained
 P.Kahn they're only immature falcons whose fathers are grey

Энд дурьдсан бор шувуу гэдэгт шонхор шувууг ойлгож буй мэт. Гэхдээ энд цагаан шонхорын “саарал” хэлбэр, эсвэл идлэг шонхор хоёрын алийг нь ойлгож буй нь эргэлзээ төрүүлж байна. Идлэг шонхор *Falco cherrug* нь Монголын тал хээрт өргөн тархсан, тоо олонтой, мөн цагаан шонхортой дүйхүйц том бие, эр зоригтой, шалмаг, дэлхийн олон оронд түүнийг одоо хир анд өргөнөөр сургаж байна (falconry bird; www.falconry.com). Дээрх онцлогийг харгалзвал идлэг шонхорыг шувуулан явахуйд ашиглаж байсан бололтой.

26. МНТ –ны 266-р зүйлийн “sayit kб'üd-i anu sibawu-ban bari'ulju daqa'ulju yabutqun”

Ш.Чоймаа Сайн хөвүүдээр ану шувуугаа бариулж, дагуулж явагтун!
 F.W.Cleaves Making their good sons to hold your falcons in hand, go
 [ye] making [from] to follow [you]
 I.Rachewiltz Go and make their fine sons to follow you, holding
 your falcons.
 W.K.Sun You can have their smart sons to keep your falcons.
 U.Onon Make their fine sons follow you as you go, holding
 your falcons.
 N.Dorjgotov, Z.Erendo Make their fine sons follow behind you, holding your
 falcons.
 P.Kahn Have their sons be your servants and hold your falcons
 for you when you hunt.

МНТ –ны 249-р зүйлд гарсан үйл явдалтай холбоотой, махчин шувуугаар ангуучлахын тулд тэжээж, сургасан шонхорыг гар дээрээ, эсвэл бэлтгэсэн суудал дээр суулган ан авч авч явдаг нь одоо хир уламжлагдан иржээ. Ялангуяа Казах ард түмэн ихэвчлэн биеэр том эм бүргэдийг анд сургаж, гар дээрээ суулган, туулай, үнэг, ховор тохиолдолд чоно авлана.

Дүгнэлт

Монголын Нууц Товчоонд дурьдаж буй шувуудын нэр, нэршил нь тухайлсан нэг зүйлийг заагаагүй, заасан ч зүйлийн шинжийг тодорхойлсон мэдээ, баримт нь хангалтгүй зэргээс шалтгаалан ихэнх зүйлийг шувуу судлалын ухааны үндэслэлтэй

бүрэн тодорхойлох боломжгүй бөгөөд бүтээлд буй шувууны нэрийг онож дүйцсэн үг олдохгүй тохиолдолд “turumtai”, “qayırqana”, “qarambai” хэмээн галиглаваас зохилтой. Орчуулагч, номын зохиогч бүр бүтээлд буй шувуунд нэр оноож буй нь нэг шувууг олон янзаар нэрлэх, улмаар шувуу судлаач бус хүмүүсийг төөрөгдүүлэхэд хүргэж байна.

Монголчууд харцага, шонхор зэрэг махчин шувууг агнуурт сургаж, улмаар шувуу, хөхтнийг агнадаг, мөн энэхүү ан авд олон хүн оролцдог байсан нь тодорхой бөгөөд цаашид энэ чиглэлийн судалгааг үргэлжлүүлэх нь чухал байна.

Монголын Нууц Товчооны зарим шувууг зүйлийн гадаад шинж, зан төрх, одоо болон түүхэн тархац, тохиолдоц зэргийг харгалзан тухайлсан нэг зүйлд хамруулахыг хичээсэн бидний оролдлого цаашид шувууны нэрийг тодорхой сэдэвт бүтээлд зөвөөр онооход тус дэм болно.

Иш татсан бүтээл

- Баттулга, Ц. (2005). Монголын руни бичгийн бага дурсгалууд. Улаанбаатар.
Гомбобаатар, С. (2006). Монгол орны төвийн бүсийн идлэг шонхор (*Falco cherrug*)-ын биологи, экологи, хамгаалал. Докторын диссертаци. Улаанбаатар.
Дамдинсүрэн, Ц. (1982). Орос-монгол толь. Улаанбаатар.
Дулам, С. (2002). Монгол бэлгэдэл зүй. Зүүд совингийн бэлгэдэл зүй, цагийн бэлгэдэл зүй. Улаанбаатар.
Дулам, С. (2009). Монгол бэлгэдэл зүй. Өнгөний бэлгэдэл зүй. Улаанбаатар.
Марко Поло (1987). Орчлонгийн элдэв сонин (Аяны тэмдэглэл). Улаанбаатар.
Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал –5 (2006). Эртний хаадыг үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой. Улаанбаатар.
Степанян, Л.С. (2003). Конспект орнитологической фауны России и сопредельных территорий. Москва.
Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар.
Черемисов, К.М. (1973). Бурятско-русский словарь. Москва.
Чоймаа, Ш. (2006) Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал –1. Монголын Нууц Товчоо. Улаанбаатар.
Эрдэнэбат, У. (2003). Монголчуудын “Шувуулахуй” агнуурын уламжлалын асуудалд. “МОНГОЛ СУДЛАЛ”. МУИС. МХСС. Боть XIX. 157-167.

- Cleaves, F.W. (1982). The Secret History of the Mongols. For the first time done into English out of the original tongue as provided with an exegetical commentary. Volume I. (Translation) Harvard University Press. Cambridge.
Dorjgotov, N. and Erendo, Z. (2006). The Secret History of the Mongols. Ulaanbaatar.
Duncker, H. (1988). Habicht (*Accipiter gentilis*) erbeutet Brandgans (*Tadorna tadorna*) auf ungewöhnliche Weise. Hamburger Avifaunistische Beiträge 21:193-194.
Gombobaatar, S. (2009). A Dictionary of Vertebrate Animals of Mongolia. Ulaanbaatar.
Gombobaatar, S, Braunlich A, Boldbaatar Sh. (2010) A field guide to the birds of Mongolia. A&C black. Helm guide. London. (In press)
Jacobsen, O. W. (1985). Goshawk *Accipiter gentilis* attacking Mallard *Anas platyrhynchos* female in water. Vår Fuglefauna 8:198-199.

- Lewis, S.B., Titus, K., Fuller, M.R. (2006). Northern Goshawk diet during the nesting season in Southeast Alaska *Journal of Wildlife Management*. 70:1156-1160
- Kahn, P. (1984). *The Secret History of the Mongols*. North Point Press.
- Onon, U. (2001). *The Secret History of the Mongols*. London.
- I.Rachewiltz, (2004). *The Secret History of the Mongols*. BRILL.
- I.Rachewiltz, (1972). *Index to the Secret History of the Mongols*. Indiana University. Bloomington.
- Sun, W.K. (1957). *The History of the Mongol Dynasty (Yuan-Chao-Pi-Shi)*. Muslim University. Aligarh.
- 元朝秘史三种, 中文出版社, (1975). Kyoto. 816 pp. (Е Дэ-хуйн эх, 311-622 тал)

SUMMARY

Mongolians have been a long tradition for symbolizing the strong birds like hawks, falcons and eagles, using and training them to hunt and these birds were often exchanged as ceremonial gifts among tribes and countries since ancient times. In this article, we studied both the bird names and phrases related to them in details and analyzed their English translations and suggested our variations. We compared the works of Prof. Ch.Choima's translation (2006) and English translations of F.W.Cleaves (1982), I.Rachewiltz (2004), W.K.Sun (1957), U.Onon (2001), P.Kahn (1984) and N.Dorjgotov, Z.Erendo (2006).

Most names of birds and terms, which mentioned in the SHM have not shown the particular species. It is troublesome to define them on the ornithological basis as for an absence of data and references, which are sufficiently accurate. Some bird names cannot be translated into English, consequently, thus it is more appropriate to use their transcriptions like "turumtai", "qayiruqana" and "qarambai". Translators and authors have been using different names for the same bird in their works, which sprawled a number of disputes among unsophisticated readers.

It is clear that Mongolians had used birds of prey like hawks and falcons, and trained them for hunting of birds and mammals. But there is the uncertainty of species names and ornithological terms. It shows that specific further studies in this field are needed.

Moreover, the significance of such studies on birds, which belongs to the particular species regarding the occurrence, recent and historical distribution, behaviour and morphological features in the SHM, cannot be underestimated within any perspectives.

Хавсралт



Амарын шонхор-Falco amurensis



Дорнын хулд-Circus spinolotus



Нөмрөг тас-Aegyptus monachus



Үлэг харцага-Accipiter gentilis



Идлэг шонхор-Falco cherrug



Монгол болжмор-Melanocorypha mongolica



Турлиах хэрээ-Corvus frugilegus Rook



Хар хэрээ-Corvus corone



Хон хэрээ-Corvus corax



Хондон ангир-Tadorna ferruginea



Хээрийн бор шувуу-Passer montanus



Шилийн сар-Buteo hemilasius



Шууман шонхор-Falco subbuteo



Идлэг шонхор-Falco cherrug



Үлэг харцага-Accipiter gentilis